

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /2013-03-27/**

Ажлын хэсгийн 31 дүгээр хуралдаан 2013 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 16 цагт Оюу толгой компанийн мэдээллийн төвд зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Засгийн газрын ахлах референт Э.Сумъяа, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн Г.Зулай, Уул уурхайн яамны Стратеги бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Т.Зууннаст, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Б.Хулан, Ашигт малтмалын газрын мэргэжилтэн Д.Мөнхсайхан, Татварын ерөнхий газрын байцаагч Д.Энхтуяа, Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, Оюу толгой ХХК-ийн олон талт хамтын ажиллагааны ахлах мэргэжилтэн Х.Лхамаа, Бороо гоулд ХХК-ийн татварын менежер Б.Ганхүлэг, Нээлттэй нийгэм форум ТББ-ын менежер Н.Дорждарь, Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, Ил тод сан ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав, Байгаль эхийн аврал сан ТББ-ын тэргүүн Н.Наранцэцэг, Хөвсгөл далайн эзэд ТББ-ын тэргүүн Б.Баярмаа, МБОИЗ-ийн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батболд, менежер М.Отгонцэцэг, Онон-Улз голынхон хөдөлгөөний тэргүүн Л.Отгонцэцэг, Монголын байгаль хамгаалах холбооны удирдах зөвлөлийн гишүүн Д.Сэнгэлмаа, Миний Монголын газар шороо хөдөлгөөний тэргүүн С.Отгонсайхан, Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 19 гишүүн оролцож ирц 55 хувьтай байв.

Мөн хуралдаанд Энержи Ресурс ХХК-ийн газрын дарга З.Сугармаа, Адам Смит Интернэйшнл (АСИ) байгууллагын захирал Жонаттан Пелл, Австралийн холбооны Засгийн газрын хуульч Сюзан Ларсен, хуульч Р.Батрагчаа, менежер П.Оюунбилэг, орчуулагч Д.Ганхуяг, ажлын албаны харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг нар оролцов.

Хурлыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нээж үг хэлэв. “Сайн байцгаана уу? Өнөөдрийн хуралд Европын банкны санхүүжилтээр хэрэгжиж буй ОУИТБС-ын хэрэгжилтийг дэмжих төслийн дарга Адам Смит Интернэйшнл байгууллагын захирал Жонатан Пелл, зөвлөх Австралийн холбооны Засгийн газрын хуульч С.Ларсен, хуульч Р.Батрагчаа, Адам Смит төслийн менежер П.Оюунбилэг, орчуулагч Д.Ганхуяг нар манай хуралд оролцож байна. Үндэсний зөвлөлд Энержи ресурс ХХК-ийн захирал Г.Батцэнгэл байдаг одоо Сугармаа хариуцаж ажиллахаар болсон тул өнөөдөр ажлын хэсгийн хуралд урьж, хурлын ажиллагаагаа танилцуулья гэсэн юм.” Гишүүдээс хурлын хөтөлбөр болон дотоод журмын талаар санал авч хурлыг эхлүүлэв. Өнөөдрийн хуралд Уул уурхайн яамны Стратеги, бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн Т.Зууннаст, Уул уурхайн ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа, ТАН эвслийн тэргүүн Н.Баярсайхан нар товч танилцуулга хийнэ. Хөтөлбөрийн талаар нэмж хасах санал байна уу.

I. ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын ОУИТБС-ын тухай хуулийн үзэл баримтлал, төслийн талаарх судалгааны ажил

Ж.Пелл: Танилцуулгын гол зорилго нь МОУИТБС-ийн талаар эрх зүйн ямар орчин байгаа талаар ярилцах юм. Ил тод байдлын санаачилгын эрх орчныг бүрдүүлэхийн тулд тухайн хуульд маань юу орсон байх шаардлагатай вэ гэдэг талаар авч үзэх хэрэгтэй юм. Мөн ямар хэлбэртэй байх нь илүү үр дүнтэй байх вэ гэдэг талаар авч үзнэ. Цаашлаад уг ажлын санхүүжилтийн талаар оруулахаар бэлтгээд байна. Дараагийн хэсгүүдэд бид юу хийх вэ гэдэг талаар ярилцах юм.

Бид Монголд үйл ажиллагаагаа эхлээд 10 хонож байна. Энэ нь өмнө нь хийгдэж байсан ажил юм. Бид ажлын хэсгийн гишүүд болон бусад олон хүмүүстэй уулзаж ярилцсан. Цаашлаад өмнө нь гаргасан ил тод байдлын санаачилгын тухай хуулийн төсөл яагаад зөвшөөрөгдөөгүй тал дээр судалгаа хийж ажилласан. Хуулийн хэсгийн талаарх танилцуулгыг хуульч С.Ларсен, Батрагчаа нар танилцуулна.

Хатагтай С. Ларсен: Миний танилцуулга энгийн юм шиг зүйлээр эхлүүлэх болно. Яагаад гэвэл зарим хүмүүс “хууль гэж юу вэ?” гэж асуудаг. Энэ нь “Төрийн бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичиг” гэж бид тайлбарладаг. Хууль эрхзүйн баримт бичгийг гаргаж хэрэгжүүлэх нь үндсэндээ 2 зорилготой явагддаг. Үүнд **Нэгдүгээрт**, эрх, үүргийг тодорхойлж өгөх, **хоёрдугаарт** тэр хүмүүсийн гаргаж байгаа зан үйлийг өөрчлөх гэсэн үндсэн зорилгоор хэрэгжиж явдаг. Хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхэд хязгаарлалтууд байдаг. Тухайлбал үндсэн хуулиар зохицуулагдах мөн бусад хуулиар зохицуулагдахаар орсон байдаг тул эдгээрийг хязгаарлалт гэж үзэж байгаа юм. Ил тод байдлын эрх зүйн орчныг бүрдүүлэх зайлшгүй шаардлагууд байна. Тухайлбал, Засгийн газар эсвэл сайд дарга нар шинээр гарч ирэхэд ил тод байдлын санаачилгыг зогсоох асуудал гаргуулахгүй байх, ил тод байдлын зарчмыг тодорхой тусгаж өгч тэдний үүргийг бий болгох шаардлагатай, чиг үүрэг болон эрх мэдлийг нь тодорхойлж өгөх, ил тод байдлыг төрөөс хараат бус байлгах, санхүүгийн хараат бус байдлыг баталгаажуулж өгөх гэсэн шалтгаануудын улмаас зайлшгүй бие даасан хуультай байх нь зүйтэй юм гэж үзэж байгаа юм. Мөн ил тод байдлын санаачилгад компаниудыг оролцуулах талаар хуулиар зааж өгөх шаардлагатай байна. Дараагийн хэсэгт санхүүжилтийн хэсэг байгаа үүнийг хамтран ажиллагч Батрагчаа танилцуулна. /Танилцуулгыг хавсаргав/

Р.Батрагчаа: Хуулийн талаар 3 сонголт байж болох юм гэж үзэж байна. **Нэгдүгээрт**, бие даасан хууль байх, **хоёрдугаарт**, газрын хэвлийн хуулийн нэг бүлэг байх эсвэл **гуравдугаарт**, салбар тус бүрийн хуульд тодорхой заалтуудыг нь шингээгээд өгье гэсэн 3 хувилбар байгаа юм. Мөн санхүүжилтийг яаж хийх вэ гэдэг асуудал гарч байна. Цаашилбал олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга нь тогтвортой байх ёстой гэдэг үүднээс зайлшгүй санхүүжилтийн талаар ярих болж байгаа юм. Тодорхой шалтгаануудын улмаас санхүүжилт нь Засгийн газраас бус өөр эх үүсвэрээс санхүүжих нь зүйтэй гэдэг хэд хэдэн санааг гаргасан байгаа. /Материалыг хавсаргав/

П.Оюунбилэг: Бид ирэх хэдэн сард хууль эрх зүйн орчин хийсэн судалгаагаа дахин шинэчилж та бүхэнд хүргүүлнэ. Саналыг бичгээр авах нь зүйтэй гэдэг зөвлөмжийг Гансүх дарга бидэнд өгсөн байгаа. Үүний дагуу та бүхнээс санал авах болно оо. Энэ ажлыг би хариуцаж ажиллах болно. Саналдаа

бүх асуудлуудыг тусгана. Үндэсний зөвлөл ямар байх вэ, ажлын хэсэг маань ямар байх вэ зэрэг бүх зүйлүүдийг тусгаж өгнө. Бид нар уул уурхайн яамныхантай уулзсан. Уул уурхайн яаман дээр хуулийн ажлын хэсэг байгуулагдсан байгаа. Тэдэнтэй манай баг хамтарч ажиллана. Одоо санал асуулгадаа орох уу. Өнөөдрийн хурлаар гол нь ил тод байдлын санаачилгын эрхзүйн орчныг зохицуулах бие даасан хууль байх шаардлагатай юу гэдэг талаар санал авах шаардлагатай байгаа. Хэрвээ хуультай байх нь зөв юм гэсэн шийдэлд хүрвэл бид дараагийн ажиллуудаа яаралтай эхлэх хэрэгтэй байгаа юм.

Ш.Цолмон: Гишүүдээс асуух асуулт байвал тавьж болно.

Н.Алгаа: Асуух юм байхгүй юм шиг байна. 2 жилийн өмнө яг энэ асуудлыг ярьж байгаад зогссон учраас асуулт алга. Энэ асуудлыг удаан хүлээсэн хэрэгжүүлээд явж байх боломж байсан боловч тухайн үед нь ажлын хэсгээс шийдвэр гаргаж өгөөгүй учраас л зогссон юм. Би бол шийдвэр гаргуулах талаар нилээд ажилласан. Эд нарын шаардсан зүйл нь сонголтоо хийгээд саналаа өгчихвөл цаашид хийх ажлаа боловсруулах учраас биднээс саналаа өгөхийг хүсэж байна. Иймд биеэ даасан хуультай байх уу гэдэг дээр саналаа өгөхийг уриалж байна.

Э.Сумъяа: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга манай улсад хэрэгжээд 6 жил болж байна. Хуульгүйгээр яваад байгаа. Зөрүүг тооцох хуулийн заалт байхгүй. Аж ахуйн нэгж, төрийн байгууллагуудыг заавал тайлан гаргах тухай заасан. Харин гаргаагүй компаниудад арга хэмжээ авах гэхээр болохгүй байна. Өөрөөр хэлбэл арга хэмжээ авах гэхээр хавтгайрах гээд байдаг. Манайд 1800 гаруй компани тайлан гаргахаар тооцоо байгаа ч бүрэн хамрагдаж чадахгүй байна. Ашигт малтмалын хууль нь харьцангуй чөлөөтэй хууль бөгөөд 1 компани хэдэн ч эрх лиценз эзэмшиж, худалдаж болдог учраас тэдгээр компаниудын бүртгэл будлиантай болдог байна. Мөн гадаадын олон олон жижиг компаниуд орж ирж байна. Тэд татвараас зайлхийж байдаг, харин томоохон компаниудын хувьд бүртгэлтэй учраас асуудал гайгүй байгаа юм. Хоёрдугаарт, хуулийн зарим заалтууд нь өөр өөр хуулиар зохицуулагддаг. Тиймээс хуулийн төсөл хууль зүйн яаман дээр очоод гацаад байдаг. Бид монголын олон хуулиндаа зохицоод ажиллаад болоод байдаг. Тиймээс одоо энэ хуулинд Батрагчаагийн үүрэг асар их байгаа. Түрүүчийн хуульчид ажиллаж чадаагүй. Одоо ч хуулийн шинжилгээ, эрхзүйн шинжилгээ хийдэг байх ёстой. Эрхзүйн шинжилгээ гэдэг бол маш нарийн ажил. Бид бол чамаас монгол улсын бүх хууль тогтоомжид эрхзүйн шинжилгээ хийсэн байхыг шаардана шүү. Ийм саналыг бол хэн ч гаргаад ирнэ. Ганцхан хууль батлуулах дээрээ тулаад Хууль зүйн яаман дээр очиход энэ зүйл чинь тэр хуулинд орсон байна аа гээд унагаадаг. Иймээс хууль батлуулах талаар Батрагчаагийн өөрөөр хэлбэл хуульчийн үүрэг хариуцлага их байх юм. Уул уурхай, эрдэс баялгийн яамтай ажиллах яах вэ гол нь хууль зүйн яаман дээр ирэхэд төслөө хамгаалж батлуулж чадах хэрэгтэй.

Б.Батболд: Нэг асуулт асууя. Түрүүн ярьсан хуулийн үндсэн шаардлагад ОУИТБС-тай холбоотой мэдээллийг гаргах, түгээх гэгчхээд нууцлах гэсэн үг орсон байна. Энэ нь ямар утгатай вэ? Нууцлах гэдэгт юуг нууцлах гээд байна вэ Үүнд тухайн компанийн менежменттэй холбоотой асуудал байна уу өөр юм байна уу. Үүнийг тодруулмаар байна. Бид аль болохоор ил тод байлгах гээд байгаа юм.

Р. Батрагчаа: Энэ нь бусад хуулийг давж гарсан хуультай байх гэсэн утгыг хэлсэн юм. Нууцын гэрээ зэрэг хуулиудыг харгалзахгүйгээр ил тод байлгах хууль байна гэдгийг ярьсан.

Б.Батболд: Таны хэлсэн эдний хэлсэн 2 зөрчилдөөд байгаа юм биш үү.

Р. Батрагчаа: Монгол улсад үндсэн хууль, олон улсын гэрээ тэгээд хууль тогтоол, журам, гэрээ гэх мэтээр зохицуулагддаг. Гэрээгээ хуулиар зохицуулаад үүрэг болгоод өгч байгаа юм.

Э.Сумъяа: Манайд нууцлалын тухай асуудал зохицуулагдаад л байгаа. Өөрөөр хэлбэл компаниудын гэрээ нууцлаг гэсэн ч тэд тайлангаа өгөөд бид ажиллаж байгаа.

Р.Батрагчаа: Бид дүн шинжилгээ хийж үзсэн. Өмнөх ажлын хэсэг дээр төрийн байгууллагын тайлагнахыг ил тод байдал гэдэгтэйгээ холиод өгчихсөн юм болов уу гэж бодсон. Магадгүй миний ойлгосноор түүнээсээ болоод хууль батлагдаагүй байж болох юм. Түүнээс төрийн байгууллагууд тайлагнах нэг өөр, түүнийг ил тод байлгах зарчмын хэрэгжүүлэх асуудал бас өөр асуудал юм.

Н.Баярсайхан: Бие даасан хууль байя гэж үзье. Хуулийн эрхзүйн үзэл баримтлалуудаа батлуулаад, хуулиа батлуулах, хэрэгжүүлэх талаар ямар хүчин чармайлт нөлөөлөлийн ажлууд хийх юм бэ? Зүгээр тэгээд хуулийн төсөл дууслаа гээд та нар явчих юм уу? Хуулийн батлагдтал та нар яаж ажиллах вэ? Баталгаа асуумаар байна.

Ж. Пелл: Эхлээд бид уул уурхайн яамаар үзэл баримтлалаа батлуулах чиглэлээр ажиллаж байгаа. Дараагийн ажил нь хуулийн төсөл боловсруулах ажил юм. Цаашдын үйл ажиллагаа нь Уул уурхайн яам болон Хууль зүйн яамтай хууль эрхзүйн ойлголтуудыг өгөх чиглэлээр голлож ажиллана. Уул уурхайн яаманд дээр байгуулагдсан ажлын хэсэгтэй хамран хуулийн төсөл боловсруулах тал дээр ажиллана. Төлөвлөж байгаа хугацааны хувьд ашигт малтмалын хууль бусад хуулиудыг намрын чуулганаар хэлэлцэгдэнэ гэсэн төлөвлөгөөтэй байгаа. Тэгэхээр намрын чуулганаар ашигт малтмалын хууль хэлцэгдэх тэр үед ил тод байдлын тухай хууль юм уу бусад хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг хэлэлцүүлнэ. Хуулийн төсөл хэлэлцэх, зөвлөлдөх асуудал дээр ажлын хэсэг дээр нягт хамтран ажиллана. Дараа нь 2 үйл ажиллагааны чиглэл байгаа. Үүнд харилцаа холбооны үйл ажиллагаа, сургалтын үйл ажиллагаа гэж байгаа. Эдгээрийг хуулийн төсөлтэйгээ уялдуулж өгөх хэрэгтэй юм. Бидний хийх ажил бол хуулийн төсөл боловсруулаад орхичих биш түүнийг батлуулах, хэрэгжилтийн талаар санал авах ч юм уу бусад ажлыг хийх боломжтой юм.

Р.Батрагчаа: Та бүхний саналын үндсэн дээр үзэл баримтлалаа боловсруулна. Сайн хуулийн 70 хувь нь үзэл баримтлал байдаг гэж ярьдаг. Бид нар ерөнхийлөгчийн хуулийн зөвлөлтэй уулзсан. Тэр хүн бол биеэ даасан хууль байх нь зүйтэй юм. Шаардлагатай бол яамуудтай холбоод өгье гэсэн. Мэдээж бид уул уурхайн яамны ажлын багтай хамтран ажиллана. Тэгэхээр яг ямар хуулийн төсөл дээр ажиллах талаар бидэнд одоо саналаа өгвөл сайн байна.

Д.Цэрэнжав: Тусгай хууль гаргахын давуу талуудыг хэллээ. Сөрөг талуудыг яагаад хэлэхгүй байна. Шинэ хууль гаргахын тулд төсөл боловсруулна гээд бид

маш их хугацаа алдах гээд байна. Нэгэндээ зарчим нь тодорхой юмыг заавал хууль энэ тэр гээд яриад байх шаардлага байна уу. Зөвхөн хуулийн төсөл гэж ярилгүй олборлох үйлдвэрлэлд тулгамдаж байгаа асуудлуудыг зэрэг судалбал яасан юм бэ гэж бодож байна. Тухайлбал маягтууд, мэдээллийн тогтолцооны асуудал, санхүүгийн асуудал гэж мэт олон асуудлуудыг судлаад тодорхой стандарт бий болгоод шийдэлд орж ажиллаж болно ш дээ. Арай гэж нэг хууль боловсруулаад батлуулахаар тухайн үед нь нөхцөл байдал нь өөр болчихдог шүү дээ. Тусдаа бие даасан хуультай байх нь зүйтэй гэж олонх үзэж болох юм. Гэхдээ юмыг наанатай цаанатай шийдвэр гаргах хэмжээнд баймаар байна.

Ш.Цолмон: Би Цэрэнжав гуайн асуултыг тодорхой болгох үүднээс тайлбар өгье. Тухайлбал Австрали улс Монголтой маш төстэй ч олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгад маш болгоомжтой хандаж байна. Тэгэхээр Ларсен хатагтай Австрали улсыг төлөөлж байгаа учраас тус улсад ямар сөрөг талууд байна гэдгийг жишээн дээр хэлбэл илүү ойлгомжтой байх болов уу.

3.Сугармаа: Бусад орнууд ямар зохицуулалтаар явж байгаа вэ?

Р.Батрагчаа: Засгийн газрын тогтоолоор зохицуулагдсан асуудлыг хуульчилж өгөх зорилготой энэ ажлыг бид хийж байна. Биеэ даасан байх, хараат бус байх зэрэг зарчим хуульчлагдвал илүү тодорхой болох юм.

Н.Дорждарь: Австрали улс нь олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг туршилтын журмаар ажиллаж байгаа. Учир нь холбооны засгийн газар орон нутгийн засаглалаасаа эрх мэдэл нь хязгаарлагдмал байдаг. Би олон улсын хэмжээнд юу хийж байна гэдгийг хэлье. Европын холбоо бие даасан хууль гаргах гэж байгаа. Нигерт биеэ даасан хууль гарсан. Тэнд 50 хүний бүрэлдэхүүнтэй томоохон ажлын алба ажиллаж маш өргөн хүрээтэй ажил хийж байна. Манай улсын хувьд ОУИТБС нь олон улсын түвшинд шинэлэг байдал тогтоох боломж байгаа юм. Энэ нь Монгол улсын засгийн газар болон компаниудад аль алинд нь ашигтай юм. Цаашилбал санхүүжилтийн талаар ОУВС зэрэг томоохон байгууллагууд ажиллаж байна. Манай улсын хувьд ОУИТБС-ыг зөвхөн Дэлхийн банк санхүүжүүлж байгаа юм биш цаана нь 10 гаруй улс орнуудын сан байгаа. Европын холбоо бие даасан ил тод байдлыг тайлагнах хууль гаргах гэж байгаа. Олон улсын ил тод байдлын дүрэмд гэрээ, лиценз зэрэг олон асуудлыг ордог. Тэгэхээр бид компаниудаа татан оролцуулах хэрэгтэй юм. Хамгийн гол нь 3 талын оролцооны зарчмын асуудал юм. Түүнээс юу тайлагнах вэ гэдэг нь тодорхой байгаа юм. Миний хувьд бие даасан хууль байх нь зөв гэж үзэж байна. Бид бусад хуулиудад тусгаад явчиж болох ч тэр хууль нь байхгүй болвол Европын холбооны энэ санхүүжилт хайран болох юм аа.

Ш.Цолмон: За баярлалаа. Өөр санал дүгнэлт хэлэх хүн байна уу?

Д.Сэнгэлмаа: Би хуулийн үзэл баримтлалт тусгах шаарлагатай зүйлүүдийг ажлын хэсгийн гишүүдэд имэйлээр явуулсан байгаа. Цаг бага байгаа тул та бүхэн түүнийг танилцана биз. Ер нь бие даасан хууль ч бай бусад хуулинд оруулсан ч бай ийм зүйлүүд орхигдоод байнаа гэдгийг дэлгэрэнгүй бичсэн байгаа тул уншиж танилцаж үзэл баримтлалд тусгаж өгнө биз дээ гэж хүсье.

Ш.Цолмон: Өөр санал дүгнэлт байна уу?

Д.Энхтуяа: Татварын ерөнхий газрыг төлөөлөн ирсэн тул саналаа хэлье. Биеэ даасан хууль байх хэрэгтэй юм гэж үзэж байна. Одоо төрийн байгууллагуудаас тайлан авахад нилээд хүндрэлтэй байгаа учраас хуулиар зохицуулж өгөх нь зүйтэй юм гэсэн санал байна.

Ш.Цолмон: Бид цаашдаа энэ асуудлаар олон дахин ярих байх. 5 дугаар сард хуулийн төлөөлөгчид маань дахин ирж ажиллана. Тэгээд үндсэн асуудалдаа орно. Улмаар 6 сар гэхэд эцсийн байдлаар гарах байх гэж төсөөлж байгаа. Цаашлаад 7,8 сард хуулийн техник ажлууд үлдэх байх гэж бодож байна. Сумъяа гуайн хэлсэн дээр манай улсын олон хуулинд байгаа юм шиг ойлголдоод байдаг зүйлүүд байдаг. Түүнийгээ дэлгэрүүлэх хэрэгтэй юм шиг байна лээ. Тэгээд судалгаагаа хийгээд бидэнд ирүүлээрэй. Мөн манай оролцогч талууд хуулийн үндэслэлийн талаар танилцуулга хийнэ гэж байсан маань хэрэггүй болж байх шиг байна. Бүх оролцогч талуудаас санал авах ёстой. Тэгээд саналаа нэгтгээд өгөх хэрэгтэй байна.

Н.Алгаа: Биеэ даасан хууль байх үгүй талаар саналаа авъя. Одоо хурал дээрээ шийдэх хэрэгтэй. Санал хураагаад шийдье.

Ш.Цолмон: За тэгвэл саналаа хэлээрэй. Уул уурхайн яамны мэргэжилтэн Т.Зууннаст санал хэлэх үү.

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. ОУИТБС-ын биеэ даасан хуультай байх нь зүйтэй гэсэн саналыг ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэн дэмжээд гишүүдийн гаргасан саналыг тусган ажиллахаар тогтов.

2. ХЭЛЭЛЦСЭН нь: Эрдэс баялагийн салбарыг хөгжүүлэхэд бодлогын баримт бичигт ОУИТБС-ын тухай хууль эрх зүйн зохицуулалтын талаар оруулах санал, хуулийн хэлбэр, агуулга, санхүүжилтийн тухай оролцогч талуудын байр суурь.

Т.Зууннаст: Бид биеэ даасан хуультай болох нь зүйтэй юм гэж үзэж байгаа. Ажлын хэсгийнхэн төрөөс баримтлах бодлогын талаарх саналаа бидэнд өгөх нь зүйтэй байх. Үүний дараа хуулийн үзэл баримтлалын талаарх судалгааг хийнэ. Үүний үндсэн дээр энэ ажил маань цаашаа явах байхаа. Уул уурхайн яамны бодлого бол биеэ даасан хуультай байх нь зүйтэй гэж үзэж байгаа. Хууль нь бараг бэлэн болсон байгаа одоо зөвхөн үзэл баримтлал дээрээ ажиллах ёстой байгаа.

Н.Алгаа: Одоо шууд санал хураагаад саналаа нэгтгэе. Энд бид шийдвэр гаргахгүй юм бол хуралдах шаардлага байхгүй юм. Тэгээд гаргасан шийдвэрээ эдэнд өгч ажлыг нь хийлгэх хэрэгтэй. 2 жил ярьсан зүйл шүү дээ. Дараа нь дахин олон нийтэд хэлэлцүүлэх зэргээр яаралтай ажиллах нь зүйтэй байна. Эрдэс баялагийн бодлогын баримт бичигт “эрхзүйн орчинг бий болгоно” гэж оруулах шаардлагатай юм бусад нь бодлогоор зохицуулагдчихна.

Н.Баярсайхан: Бие даасан хуультай байх нь чухал үүнийг дэмжиж байна. Т.Зууннастын хэлсэн үзэл баримтлал боловсруулах ажлын хэсгийг сайдын тушаалаар гаргуулж ажиллах нь зүйтэй гэсэн саналыг дэмжиж байна. Мөн эрдэс баялагийн бодлогын баримт бичгийнхээ төслийг бидэнд явуулж санал авбал яаж байна. Бид бас үзэж танилцах нь зүйтэй байх. Хуулийн төслийнхөө хажууд бас

нэг хувилбар авч явбал яасан юм гэсэн саналыг тавьж байна. Хэрвээ өөр хуулиудад хавсаргах бол ийм хуулиудад ингэж оруулна гэсэн санаагаа гаргасан байх нь зөв байх байна. эндээс мэдээж шийдвэр гарахын тулд санал аваад ажлаа урагшлуулах нь зүйтэй байх гэсэн байр суурьтай байна.

Ш.Цолмон: Одоо гараа өргөөд санал хураачих уу. Ерөнхийдөө санал нэгдмэл байх шиг байна.

Н.Баярсайхан: Гар өргүүлээд саналаа хураасан нь дээр

Ш:Цолмон: “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай ” биеэ даасан хууль байх нь зүйтэй гэсэн шийдвэрийг гаргалаа.

Н.Дорждарь: Алгаа гуайн хэлснээр олон нийтээр хэлэлцүүлэх талаар Адам Смитийн багийнхан төлөвлөгөө гаргаад хэрэгжүүлэх ажлыг хийх нь зүйтэй юм. Зөвхөн энэ өрөөнд хэдэн хүн цуглуулаад асуугаад байх биш өөр арга замаар хэлэлцүүлэх хэрэгтэй.

Н.Баярсайхан: Иргэний зөвлөлөөр хэлэлцүүлэх нь зүйтэй.

Н.Алгаа: Ашигт малтмалын хууль хэрэгжүүлсэн загвараар иргэний төлөөлөлийг оролцуулж хэлэлцүүлэх ёстой.

Б.Батрагчаа: Одоо эрдэс баялагийн бодлогын ажлын хэсэг нь гарчихсан ажиллаж байгаа юм байна. Тэнд ямар үг, өгүүлбэрээр оруулах вэ гэдэг саналаа гаргаад бидэн рүү имэйлээр явуулах хэрэгтэй байна.

Н.Баярсайхан: Эрдэс баялагийн бодлогын баримт бичгийн төслийн авч үзье.

Б.Батболд: Тэр бодлогын баримт бичигт олборлох үйлдвэрлэлийн санаачилгын талаар оруулж өгөхгүй бол дараагийн бидний гаргах хууль боломжгүй болох юм.

Н.Баярсайхан: Төслөө явуулчих, тусгачихсан байвал бид нэмэх шаардлагагүй юм.

Ш.Цолмон: биеэ даасан гэж үг орох шаардлагагүй. Эрх зүйн орчныг тодорхой болгох гэж оруулах хэрэгтэй байх. За ингээд хурлын ажиллагаа дууссаныг мэдэгдье. Та бүхэнд их баярлалаа амжилт хүсье.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1.Эрдэс баялгийн бодлогын баримт бичгийн төсөлд ОУИТБС- ын талаар дээр саналаа оруулахаар шийдвэрлэв.

2.Адам Смит төслийн багаас оролцогч тал бүрт хуулийн төсөлд орох агуулга, хэлбэрийн асуумж явуулна. Оролцогч тал бүр байр сууриа илэрхийлнэ.

Ажлын хэсгийн хурал 17 цагт 45 минутад өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга,
ажлын албаны зохицуулагч

Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ажлын албаны санхүүгийн мэргэжилтэн

А.Отгонтунгалаг